



## УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.03.30 № 1/651

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДАД

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэлд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний 12 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: [procurement@fchm.edu.mn](mailto:procurement@fchm.edu.mn)

Хаяг: УНТЭ-ийн 1 давхар 103 тоот.


Хавсралт 1 хуудастай.

Жич: Бэлэн байгаа эмнэлгийн хэрэгсэлд үнийн санал ирүүлнэ үү.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1651 дугаар албан бичгийн хавсралт



Нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалт

№	Эмнэлгийн хэрэгслийн нэршил	Техникийн тодорхойлолт	Тоо
1	Титэм судасны эмтэй стент (DES)	<p>Диаметр: 2.5мм, 2.75мм, 3.0мм, 3.5мм, 4.0мм Уртын сонголт: 8мм, 12мм, 15мм, 18мм, 23мм, 28мм, 33мм, 38мм</p> <p>Стентний материал: Cobalt Chromium</p> <p>Стентний ханын зузаан: 81 мкм</p> <p>Эмэн бүрхүүл: Everolimus 1.5T ба 3.0T MRI шинжилгээнд аюулгүй</p> <p>Полимер: Флуорополимер - гадаргуудаа альбуминыг татсанаар тромб үүсэх, үрэвсэл үүсэх явцыг дарангуйлна.</p> <p>Стентний бүтэц: Multi-Link буюу олон холбоос бүхий бүтэцтэй ба судасны ханыг гэмтээхгүй, үрэвсэл үүсгэхгүй, судасны хананы нөхөн төлжилтийн явцыг хурдасгадаг.</p> <p>Уян хатан чанар сайн тул тахиралсан судас, судасны нарийслийн дундуур туулах чадвар сайн, үзүүрийн хэмжээс бага тул нарийслийн дундуур нэвтрэх чадвар сайн</p> <p>Стентний доторхи баллон нь 2 давхар ба өндөр даралтаар тэлж өгснөөр кальцификаци бүхий нарийслийн үед стентийг сайн тэлдэг.</p> <p>Стентийг тэлсэний дараа уртын хэмжээс нь богиносдоггүйгээс гадна эмэн бүрхүүл хууларч гэмтэхгүй.</p> <p>Стент тавьсан судас 1-3 жилийн дотор эргэн нарийсах эрсдэл маш бага буюу 0.5-0.7%</p> <p>Чихрийн шижинтэй өвчтөнд хэрэглэж болно /Spirit V Diabetic study - аар чихрийн шижинтэй өвчтөнд аюулгүй ба үр дүнтэй нь нотлогдсон/ Abbott брэндийн Xience эмтэй стент нь дэлхийн зах зээлийн маш өндөр хувийг эзэлдэг бөгөөд одоогоор 10+ сая суулгац, 100,000+ өвчтөнийг судалсан, 100+ судалгаа, 10+ жилийн мэдээллийн санг бүрдүүлж эмч нарийн хамгийн найдвартай сонголт болж чадсан. Уг хэрэгсэл нь олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан, практикт өргөнөөр хэрэглэгддэг бүтээгдэхүүн болно.</p>	20